



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 4 сарын 23 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах тухай

Агаарын тээврийн МИАТ ХК-ийн Боинг 737-800, EI-GXV агаарын хөлгийн хөл ангид гэмтэл гарсан шалтгаан нөхцлийг тогтоох, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 2.5, 4.1.6, 4.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.БНСУ-ын агаарын тээвэр, Төмөр замын ослыг шинжлэн шалгах байгууллагын лабораторид Боинг 737-800, EI-GXV агаарын хөлгийн дугуйны эвдэрч гэмтсэн эд ангийг шинжилгээ хийлгэх ажлаар 2013 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс 5 дугаар сарын 03-ны өдрийг дуустал Солонгос улсын Сөүл хотод томилон ажиллуулсугай.

2.О.Бат-Оршихын гадаадад томилолтоор ажиллахтай холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгээс хүссүгэй.

3.Гадаадад томилолтоор ажилласан тухай тайланг албаны удирдлагад танилцуулахыг О.Бат-Орших-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.НАРАНХҮҮ



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, Иргэний нисэхийн багц дүрэм 203 –ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. JU-5566 бүртгэлийн дугаартай МИ-8 нисдэг тэрэг 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотоос Цахар, Минжийн уулзвар чиглэлд захиалгат нислэг үйлдэж явахдаа ослын буулт хийсэн шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч: Х.Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч

Гишүүд: М.Баатаржав, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

И.Энхчулуун, нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч


О.Бат-Орших, нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

Нарийн бичгийн дарга: А.Ууганбаяр, нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны мэдээлэл судалгааны мэргэжилтэн

2. Шинжилгээний ажилд шаардлагатай мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулахыг багийн ахлагч (Х.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, Осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зааврын дагуу хийж гүйцэтгэж, үйл ажиллагааны явцыг цаг тухайд нь танилцуулж байхыг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ЦОЛМОН

2013 00032